



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Заавар батлах тухай” А/537 дугаар тушаал, “Түр заавар шинэчлэн батлах тухай 2022 оны А/36 дугаар тушаал, ХӨСҮТ-ийн зөвлөмж зэргийг үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварын эрсдлээс сэргийлэх ажлын хүрээнд “Халдвараас сэргийлье” сэдэвт аяныг 2022 оны 02-р сарын 14-28-ны хооронд бүх тасаг нэгж, эмч эмнэлгийн ажилтнуудын дунд зохион байгуулан явуулсугай.

2. “Халдвараас сэргийлье” сэдэвт аяны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аяны удирдамжийг хоёрдугаар, аяныг дүгнэх шалгуур үзүүлэлтийг гуравдугаар, аяны үйл ажиллагаанд шаардагдах төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Аяны ажлыг чанартай зохион байгуулан ажлын хэсгийг удирдлага, арга зүйгээр хангаж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.


3. Аяны үйл ажиллагаанд тасаг нэгжүүдээ болон эмч эмнэлгийн ажилчдаа идэвхитэй оролцуулж халдварын эрсдлээс сэргийлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллахыг тасаг нэгжүүдийн дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тасаг нэгжүүдийн халдвар хамгааллын дэглэмийн үйл ажиллагаанд хяналт тандалтыг тавьж, мэргэжил арга зүйгээр ханган эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Тус аяны үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг байгууллагын зохих төсвөөс гаргахыг ахлах нягтлан бодогч /С.Оюун-эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.


5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга /Д.Гэжиймаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын  
2022 оны 02 дүгээр сарын 09 –ны өдрийн  
А/11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Ажлын хэсгийн ахлагч
2. Гишүүд:

Т.Гэрэлсүрэн—ЭЭО дарга  
С.Өлзийжаргал-тархвар судлаач  
Б.Халиунгэрэл—СА-ны дарга  
Ц.Оюунчимэг –чанарын менежер  
Т.Дэлгэрмаа---ЗАА-н дарга

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын  
2022 оны 02 дүгээр сарын 09 –ны өдрийн  
А/11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## “ХАЛДВАРААС СЭРГИЙЛЬЕ” СЭДЭВТ АЯНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг: Үндэслэл:

Дэлхий нийтэд “Омикрон” хувилбараар үүсгэгдсэн коронавируст халдвар дэлхийн 149 улсад тархаж 552 мянга гару тохиолдол бүртгэгдээд байна. Одоогоор коронавируст халдварын 4 дэх давалгаа эхэлж хүн амын дундхалдварын тохиолдлын тоо нэмэгдэхийн зэрэгцээ эрүүл мэндийн байгууллагад халдвар бүртгэгдэж, эрүүл мэндийн ажилтнууд халдварт өртөж байна. Улсын хэмжээнд 2022 оны 1-р долоо хоногт 358 эрүүл мэндийн ажилтан КОВИД-19 -өөр өвдсөн ба эдгээрийн 134 нь давтан халдвар авсан байна. 2022 оны 1-р сард ЭМТ-ийн 52 эмч эмнэлгийн ажилтан КОВИД-19 -өөр өвдсөн ба эдгээрийн 23 нь давтан халдвар авсан байна. Иймд эмнэлэг эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдварын дэгдэлт бүртгэгдэх, эрүүл мэндийн ажилтнуудыг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах явдал юм.

Хоёр. Зорилго:

ЭМТ-ийн тасаг нэгж, эмч эмнэлгийн ажилтнуудын дунд коронавируст халдварын эрсдлээс сэргийлэх, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээрх тушаал заавар журмуудын хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг сайжруулж халдварын эрсдлийг бууруулах

Гурав. Хамрах хүрээ:

ЭМТ-ийн Хэвтэн эмчлүүлэх тасаг, амбулатори, нийгмийн эрүүл мэндийн алба, ЗАА-н тасаг болон бүх эмч эмнэлгийн ажилтнууд

Дөрөв. Хугацаа:

2022 оны 02-р сарын 14-28-ны хооронд

Тав: Аяны хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын чиглэл

1. Тасгуудын халдварын сэргийлэлт хяналтын багууд аяны хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган үр дүнг тооцож ажиллах

2. Тасаг нэгжүүд болон эмч эмнэлгийн ажилтнууд халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр тодорхой үр дүнтэй ажлыг санаачлан хийж бусдадаа түгээсэн байх
3. Тасаг нэгжийнхээ эмч эмнэлгийн ажилчдынхаа дархлааг дэмжих, эрүүлжүүлэх, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр тодорхой санаачилга гаргаж ажиллах
4. Халдвараас сэргийлэх чиглэлээр үйлчлүүлэгчдэд зориулсан арга хэмжээг авч ажиллах
5. Ажлын хэсгийн гишүүд эмч ажилтнуудын гар угаах, халдваргүйжүүлэх дадлыг үнэлж дүгнэлт гаргах
6. Тасаг, нэгж, эмч ажилтнуудыг шалгаруулах үнэлгээний шалгуурыг тус тусд нь гаргаж үнэлнэ.
7. Тасаг нэгжүүд аяны ажлын тайлангаа 2022 оны 2-р сарын 27-28-ны хооронд ажлын хэсэгт ирүүлсэн байна

Зургаа: Шалгаруулалт урамшуулал

Аяны ажлын үр дүнг 2022 оны 3-р сарын 1-3-ны хооронд ажлын хэсгийн гишүүд шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж онооны дарааллаар байр эзлүүлэн дараах чиглэлээр шалгаруулж урамшууллыг олгоно .

1. Тасгуудаас нэг тасгийг шалгаруулж----150,000 төг урамшуулалтай
2. Кабинет нэгжүүдээс 1,2-р байрыг шалгаруулж 1-р байрыг 100,000, 2-р байрыг-80,000-төг
3. Эмч эмнэлгийн ажилтнуудаас 3 хүнийг шалгаруулж 70,000,60,000,50,000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулна.

Удирдамж боловсруулсан:


Тархвар судлаач  С.Өлзийжаргал

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын  
2022 оны 02 дүгээр сарын 09 –ны өдрийн  
А/11 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**АЯНЫГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Оноо / 0-5 /
<b>Нэг: Тасгийн шалгуур үзүүлэлт</b>		
1.1.	Аяны хугацаанд хийх ажлын төлөвлөгөө гаргаж баталгаажуулсан байдал	
1.2	Төлөвлөгөөний биелэлт	
1.3	Тасгийн ХСХБ-ын үйл ажиллагаа	
1.4	Халдварын сэргийлэлтийн чиглэлээр шинээр санаачилж хийсэн ажил бусдадаа түгээсэн байдал	
1.5	Үйлчлүүлэгчдэд чиглэсэн ажил зохион байгуулсан байдал	
1.6	Гарын эрүүл ахуй сахилтын нөхцөлийг бүрдүүлсэн байдал	
1.8	Эмч эмнэлгийн ажилтан бүр гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшсэн байдал	
<b>Хоёр: Кабинет нэгжийг үнэлэх шалгуур үзүүлэлт</b>		
2.1.	Гарын эрүүл ахуй сахилтын нөхцөлийг бүрдүүлсэн байдал	
2.2.	Кабинет нэгждээ гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх иж бүрдлийг бүрдүүлж хэрэглэж хэвшсэн байдал	
2.3	Халдварын сэргийлэлтийн чиглэлээр шинээр санаачилж хийсэн ажил бусдадаа түгээсэн байдал	
2.4	Үйлчлүүлэгчдэд чиглэсэн ажил зохион байгуулсан байдал	
2.5	Хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу зөв өмсөж хэвшсэн байдал	
<b>Гурав: Эмч эмнэлгийн ажилтныг үнэлэх шалгуур</b>		
3.1	Хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу зөв өмсөж хэвшсэн байдал	
3.2	Эмч эмнэлгийн ажилтан бүр гадаргуугийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшсэн байдал	
3.3	Халдварын сэргийлэлтийн чиглэлээр шинээр санаачилж хийсэн ажил бусдадаа түгээсэн байдал	
3:4	Гарын эрүүл ахуй сахих дадлыг хэвшүүлсэн байдал	

Хан-Уул Эрүүл Мэндийн Төвийн Даргын  
2022 оны 02 дүгээр сарын 09 –ны өдрийн  
А/11 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



Аяны үйл ажиллагаанд шаардагдах төсвийн тооцоо

№	Нэр төрөл	Нэгж тоо	Төсөв / төг/	Тайлбар
1	Шагнал урамшуулалд	6	510,000	1 тасаг , 2 кабинет, 3 ажилтан
2	Нийт дүн		510,000	

Хянасан:

Ахлах нягтлан бодогч

С.Оюун-эрдэнэ

Тооцоо гаргасан:

Тархвар судлаач

С.Өлзийжаргал